


Таны нэхэмжлэлийн талаар гаргасан Хөдөлмөр, үйлдвэрийн хэлтэсийн шийдвэрийг хэрхэн эсэргүүцэх вэ



Эсэргүүцэл гэж юу вэ?

Эсэргүүцэл гэдэг нь ажилчдад олгох нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн талаар гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаагаа илэрхийлж буй таны захиа юм. Таны эсэргүүцлийг уг шийдвэрийг хүлээн авсанаас хойш 60 хоногийн дотор хүлээн авах шаардлагатай.

Таны эсэргүүцэл нь дараах зүйлсийг багтаасан байх ёстой:

- Таны нэр ба нэхэмжлэлийн дугаар.
- Газрын шийдвэрийн огноо.
- Таны санал нийлэхгүй байгаа шалтгаан, үүн дээр нэмээд ямар нэг үйлчилгээ үзүүлэгчийн акт эсвэл шийдвэрийг буруу гэдгийг харуулна гэж таны итгэж байгаа бусад мэдээллүүд.

Өөрийн эсэргүүцэл эсвэл өргөдлийг хаашаа илгээх ёстой вэ?

- Эсэргүүцлээ <https://secure.Lni.wa.gov> дээрх Claim and Accounts Center-ийг (Нэхэмжлэл ба Бүртгэлийн Төв) ашиглан онлайн аар илгээх. (Энэ сонголтыг ашиглахын тулд та нууц үг бүхий бүртгэл тохируулах шаардлагатай). ЭСВЭЛ
- Бичгээр үйлдсэн эсэргүүцлийг илгээх: Department of Labor & Industries, P.O. Box 42491, Olympia WA 98504-4291. ЭСВЭЛ
- Board of Industrial Insurance Appeals (BIIA), Executive Secretary, P.O. Box 42401, Olympia WA 98504-2401-д бичгээр үйлдсэн эсэргүүцлээ илгээх эсвэл www.BIIA.wa.gov хуудас дээрх цахим маягтаар өөрийн эсэргүүцлийг илгээх. (Даатгалын Гомдлын Зөвлөл [Board of Industrial Insurance Appeals, BIIA]-ийн зүгээс хийхийг тушаагаагүй бол Labor & Industries [Хөдөлмөр, үйлдвэрийн газар] нь таны санаа бодлыг авч үзэх боломжгүй байж магадгүй.)

Газар нь миний эсэргүүцлийг хүлээн авснаар юу тохиолдох вэ?

Нэхэмжлэлийн менежер таны нэхэмжлэлийг хянах бөгөөд дараах зүйлсийн нэгийг хийх болно:

1. Анхны шийдвэрийг өөрчлөх. Та шинэ шийдвэр бүхий захиа буюу захирамжийг, эсвэл хоёуланг нь хүлээн авна.
2. Анхны шийдвэрийг зөв гэж шийдэх. Анхны шийдвэр нь зөв байсан гэдгийг баталсан захирамжийг та хүлээн авах болно. Хэрэв та үүнтэй санал нийлэхгүй хэвээр байгаа бол Үйлдвэрлэлийн Даатгалын Гомдлын Зөвлөлд (BIIA) бичгээр шинэ шийдвэрийн талаар гомдол гаргаж болно. Гомдол гаргахад зориулсан цаг хугацааны хүрээ ба шуудангийн хаяг нь захирамж дээр байх болно.

3. Илүү мэдээлэл хэрэгтэй гэж шийдэх. Шийдвэрийг хүлээлгэнд оруулах захирамж, илүү мэдээлэл хүссэн захидлыг эсвэл хоёуланг нь та хүлээн авах болно. Нэхэмжлэлийн менежер танаас, таны эмчээс эсвэл таны ажил олгогчоос илүү мэдээлэл хүсэж магадгүй.

Таны эсэргүүцлийн талаарх шийдвэр нь илүү мэдээлэл шаардлагатай эсэхээс хамааран 30-аас 60 өдөр эсвэл илүү удаан хугацаа шаардаж болно. Хэрэв та эсэргүүцлээ илгээснээс хойш 30 хоногийн дотор хариу хүлээн аваагүй бол нэхэмжлэлийн менежертэй холбоо барина уу.

Хэрэв би эсэргүүцэл, гомдол гаргаагүй эсвэл 60 өдрөөс хойш гаргасан бол юу тохиолдох вэ?

Хэрэв та 60 өдрийн дотор эсэргүүцэл, гомдол гаргаагүй бол газрын шийдвэр нь эцсийнх байна. Энэ нь та сүүлд шийдвэрийн талаар эсэргүүцэл, гомдол гаргах боломжгүй гэсэн үг юм.

Хэрэв өөрийн нэхэмжлэлийн талаар асуултууд, санаа бодлууд байгаа бол хэнтэй холбоо барих ёстой вэ?

- Нэхэмжлэлийн тодорхой асуултуудад зориулж таны хэргийг зохицуулж байгаа нэхэмжлэлийн менежер. Таны нэхэмжлэлийн менежер нь дуудлагад тусалцаа үзүүлэхийн тулд хэлмэрчидтэйгээ уулзах эрхтэй.
- Нэхэмжлэлийн ерөнхий мэдээлэлд зориулсан газрын төлбөргүй дугаар, 1-800-547-8367. Энэ дугаар нь Испани хэл дээр мэдээлэл сонсох боломжийг олгоно.

Илүү тусламжид зориулж та дараах үнэгүй үйлчилгээнүүдээс асуухыг мөн хүсэж болох юм:

- 1-800-255-9752 дээрх Project Help (Төслийн Тусламж). Хэлмэрчийн үйлчилгээ хэрэгтэй байж болно.
- 1-888-201-1014 дээрх Зохицуулагдсан Хууль зүйн Боловсрол, Зөвлөгөө ба Лавлагаа (Coordinated Legal Education, Advice and Referral, CLEAR). Энэ үйлчилгээ нь бага орлоготой ажилчдад ажлын өдрүүдэд голдуу өглөөний 09:15-аас үдийн 12:15 хүртэл утсаар зөвлөгөө ба лавлагаа өгдөг. Мэдээлэл нь Испани хэл дээр боломжтой.

Төслийн Тусламж эсвэл CLEAR-ийн холбоо барилт нь газрын шийдвэрийн эсэргүүцэл эсвэл гомдлыг хамрахгүй. Газрын шийдвэрийг эсэргүүцэхийн тулд энэ баримт бичгийн хуудсанд үзүүлсэн алхамуудыг дагана.

PUBLICATION F242-363-278 (Mongolian Cyrillic) [04-2019]